



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 08 дугаар сарын 23 өдөр

Дугаар 76

Хэрлэн сум

ЛХХVI ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 76 дугаар хуралдаан 2021 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 10:00 цагт танхимаар 70,4 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын одоогийн нөхцөл байдлын мэдээллийг танилцуулах,

*Аймгийн ерөнхий төрхөөр судлаач*

2.Батлагдсан тохиолдол болон ойрын хавьталуудад тавих хяналтын талаар хэлэлцэх,

*Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар,  
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

3.Гэрийн тусгаарлалтын 7 хоног, 6 дахь хоногийн шинжилгээг хийлгэх эсэх, сайн дураар шинжилгээ өгөх эсэх талаар хэлэлцэх,

*Эрүүл мэндийн газар*

4.Хөлөнбуйр сумын шалган нэвтрүүлэх, хяналтын цэгийн үйл ажиллагааг буулгах эсэх талаар хэлэлцэх,

*Эрүүл мэндийн газар*

5.Коронавируст халдвар /Ковид-19/-аар хөнгөн өвчилсөн иргэдийг гэрээр эмчлэх, тусгаарлах байр бэлтгэх,

6.Сумын Онцгой комисст үүрэг чиглэл, зөвлөмж хүргүүлэх, мэдээлэл хийх балийг томилгоожуулах талаар хэлэлцэх,

*Онцгой комиссын гишүүд*

7.Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах чиглэлээр албан даалгавар гаргах талаар хэлэлцэх,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

8.Олон нийтэд ухуулга сурталчилгааны ажил зохион байгуулах,

  
М.Бадамсүрэн  
х/ч Б.Цогтбалр

АЗДТГ-ын Олон нийттэй харилцах алба

9.Улсын Онцгой комиссоос ирүүлсэн албан даалгавар танилцуулах,  
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

10.Иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн  
хүсэлт танилцуулах,  
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт:

1.1.Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь  
түргэвчилсэн шинжилгээг 14 хоног тутам ажилтан, албан хаагч нараас авч байх,  
шинжилгээ авах ажилтныг сургаж бэлтгэх,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа-д:

1.2.Коронавируст халдвар /Ковид-19/-ыг илрүүлэх, шинжилгээ авах цэгт  
ажиллах хүч хэрэгслийг нэмэгдүүлэх,

1.3.Халдвар голомтлон тархсан бүс нутгаас ирсэн иргэдийг өөрсдийн  
ухамсарт нь тулгуурлах, өмнө мөрдөгдөж байсан 7 хоногийн гэрийн тусгаарлалтыг  
цуцлах, шинж тэмдэгийн дуудлага, батлагдсан тохиолдлын ойрын хавьтал болон  
сайн дурын шинжилгээнд хамрагдах тохиолдолд шинжилгээний цэгт ирж  
шинжилгээнд хамруулах,


Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,  
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа нарт:

2.1.Хөлөнбуйр сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгийн үйл ажиллагааг  
2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс татан буулгах,

Гурав.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа-д:

3.1.Хувийн хэвшлийн эмнэлэг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын  
харъяа ахмадын амралтын газрын байрыг иргэдийг тусгаарлан эмчлэх байраар  
ашиглах,

3.2.Эмийн нөөцийн талаар 5 хоног тутам эмийн сангуудаас мэдээлэл авч  
аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга, аймгийн Тагнуулын газрын дарга  
нарт танилцуулах,

 / М.Бадамсүрэн  
/ х/ч Б.Цогтбаяр

3.3.Хариу арга хэмжээ, тандалт судалгаа, шинжилгээний багт ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж, сэтгэл зүйчид урамшуулал олгох талаар судалж танилцуулах,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,  
Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Аюушмаа,  
Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,  
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир,  
Улаан загалмайн хорооны дарга Б.Ганболд,  
Төрийн байгууллагын дарга нарт:

3.4.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан аймгийн Шуурхай штабын Тандалтын баг болон Шинжилгээний багт төрийн албан хаагч, сайн дурын гишүүд, шаардлагатай тээврийн хэрэгслийг нэмэлтээр дайчлан ажиллуулах,



Дөрөв.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн А.Нансалмаа нарт:

4.1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын "Дельта" хувилбарын тархалт болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эхэлж байгаатай холбогдуулан сумдын Онцгой комисст холбогдох үүргийг албан бичгээр хүргүүлэх,

Тав.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга,  
Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,  
Боловсрол, соёл урлагийн газрын дарга,  
Онцгой комиссын гишүүн А.Нансалмаа нарт:

5.1.Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны "Түр журам батлах тухай" А/292, А/525 дугаар хамтарсан тушаалын хэрэгжилтийг хангаж, салбар хоорондын уялдаа холбоог зохицуулах,

Зургаа.Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,  
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир,  
"Чойбалсан хөгжил" ОНӨААТҮГ-ын дарга н.Амарцэнгэл нарт:

/  / М.Бадамсүрэн  
/  / х/ч Б.Цогтбаяр



6.1.Чойбалсан хотын хог хаягдал болон автозамын тоос, шороог цэвэрлэх, санал танилцуулах,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх,  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа нарт:

6.2.Чойбалсан хотын авто замын ус тогтож буй бүх уулзваруудын судалгааг гаргаж ус зайлуулах систем хийх ажлын зардлыг 2022 оны төсөвт тусгах, хийх ажлын жагсаалтад оруулах,

6.3.Чойбалсан хотын засмал замруу орж буй хэсэгт хайрган хучилттай болгох техникийн шийдлийн талаар санал танилцуулах,

Долоо.Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат-д:

7.1.Улсын Онцгой комиссоос ирүүлсэн "Халдвартын эрсдэлтэй олон нийтийг хамарсан үйл ажиллагааг зохион байгуулахгүй байх тухай" албан үүргийг хэрэгжүүлж ажиллах сумын Онцгой комиссын шийдвэр гаргаж хяналт тавих талаар сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт чиглэл өгөх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

7.2."ТВЕА" ХХК-аас 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдөр аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Өвдөг-Баянхошуу хилийн боомтоор шаардлагатай бараа материал нэвтрүүлэх тухай хүсэлт" албан бичгийг Улсын Онцгой комисст уламжлан шийдвэрлүүлэх,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Халхгол сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга Х.Хүрэл-Эрдэнэ  
Хил хамгаалах байгууллагын дарга нарт:

7.3.Жил бүр зохион байгуулдаг хил хамгаалах туслах хүчний байгууллагуудын зөвлөгөөнийг Буйр нуурын эрэгт задгай талбайд зохион байгуулах хүсэлтийн дагуу оролцох бүрэлдэхүүнийг түргэвчилсэн шинжилгээнд хамруулах, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэхэд хяналт тавьж зохион байгуулахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА



М.БАДАМСҮРЭН

/ / М.Бадамсүрэн  
/ / х/ч Б.Цогтбаяр